



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 1/07

Улаанбаатар хот

Коронавируст халдвараас сэргийлэх
өндөржүүлсэн бэлэн байдлын үед тусгай
горимд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/108 дугаар захирамж, төвийн даргын 2019 оны А/10 тоот тушаалаар баталсан "Нийгмийн хамгааллын тусгай төвийн хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.5, 10.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн коронавируст халдвараас сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын тусгай горимд шилжүүлсүгэй.
2. Улсын Онцгой комиссын 2021 оны 18 дугаар тушаалаар баталсан "Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ыг чанд мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад анхааруулсугай.
3. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
4. Өндөржүүлсэн бэлэн байдлын тусгай горимд шилжүүлсэнтэй холбогдуулан төвийн түр хоноглох байранд байрлаж буй иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлан, хяналт тавин, мэдээлэл солилцож ажиллахыг тухайн өдрийн ээлжийн жижүүр болон хариуцлагатай жижүүрт үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ЦЭРЭНДУЛАМ

318060430

Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын
 2021 оны 02 сарын 24 ны өдрийн
 4/02 дугаартай тушаалын хавсралт



ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны 02 дугаар сарын 24

Улаанбаатар хот

Д/Д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах ажилтны нэр	хугацаа
1	2	3	4
1	Иргэдийн гарах хөдөлгөөнийг хязгаарлах	Нийгмийн ажилтан, жижүүр, хариуцлагатай жижүүр	Өдөр бүр
2	Халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэх	Нийт ажилтнууд	Өдөр бүр
3	гадна орчны 50м-т болон өрөө тасалгаа, гэрийн цэвэрлэгээ, халдваргүйтгэл, агаар сэлгэлт тогтмол хийж, хяналт тавих	Эмч, үйлчлэгч, жижүүр хариуцлагатай жижүүр	-
4	Шаардлагатай эм, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцөд анхаарах, тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангах	Нягтлан бодогч, нярав	-
5	Ажилтан албан хаагчдыг нэг удаагийн хамгаалах хэрэгслээр хангах/Малгай, бээлий,...г м/	Нягтлан бодогч, нярав	-
6	Иргэд болон ажилтнуудад дархлаа дэмжих аарц, чацаргана өгөх	Нягтлан бодогч, нярав, тогооч	Өдөрт нэг удаа
7	Иргэдэд сургалт мэдээлэл өгөх чиглэлээр зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх	Ахлах арга зүйч, нийгмийн ажилтнууд, сэтгэл зүйч, эмч	Өдөр бүр хуваарийн дагуу
8	Мэдээ тайланг тогтоосон хугацаанд холбогдох дээд байгууллагад хүргүүлэх	Бичиг хэргийн ажилтан	-
9	Албан хаагчдыг богиносгосон цагаар ажиллуулах, хариуцлагатай жижүүрийн хуваарь гаргах	Ахлах арга зүйч	03.01
10	Хүндэтгэх шалтгаантай ажилтныг цахимаар ажиллах нөхцлөөр хангах	Ахлах арга зүйч	-